



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Их хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” 382 дугаар тогтоол, 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 192, 194 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/641 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсон зарим төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон тул газрын нийт албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдлийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн баталсан үндсэн цалинг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс, шинээр олгосон төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус тооцож сар бүр олгож ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ